ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 25 өдөр          Дугаар 04          Баянтал сум

Төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.10, 2.11, 2.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төсөл сонгон шалгаруулах товыг журмын дагуу 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахаар тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА          Д.МӨНХ-ЭРДЭНЭ